

**XX зууны Монголын дээд боловсролын хөгжлийн
түүхийн үечлэлийн асуудалд**

З.Баасанжав. МУИС-ийн НШУС-ийн түүхийн тэнхимийн багш

Өгүүллийн товч утга: Монголын дээд боловсролын хөгжлийн эх суурь XIII зуунд тавигдсан авч нэгэн хэсэг хугацаанд тасалдсан байна. Гэвч XX зуунд тасарсныг залгаж, орчин цагийн дээд боловсролын систем үүсч, бүрэлдэн бий болж хөгжсөн билээ. 1942 онд МИУС байгуулагдсанаар гараагаа эхэлсэн орчин цагийн монголын дээд боловсролын систем нэгэн жаран илүү хугацааг туулан хөгжиж ирэв. Өнөөдөр манай дээд боловсролын салбарт бүтэц, зохио байгуулалт, эрх зүйн хийгээд сургалтын зохирилго, агуулга, арга зүй, технологи, эдийн засаг зэргийг бүхэлд нь хамарсан шинэчлэл хийгдэж байна.

Түлхүүр үг: дээд боловсрол, дээд боловсролын хөгжлийн үндсэн үечлэл, их сургууль, дээд сургууль, дээд сургууль, коллеж, шаталсан сургалт, бакалавр, магистр, доктор, дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, удирдах зөвлөл, шинэчлэл, магадлан итгэмжлэл.

Монгол үндэстэн XIII-XIV зуунд хүчирхэгжин, Ази-Европыг бараг бүхэлд нь хамарсан эзэнт гүрнийг байгуулан, хүн төрөлхтний хөгжлийг оройлон манлайлж байсны нэгэн гол шалтгаан нь боловсрол, эрдэм мэдлэгийг чухалчлан үзэж, эрдэм мэдлэгтэй авъяас чадвартай, мэргэн цэцэн хүмүүсээр төрийн алба залгуулахыг эрхэмлэн, нийгмийн дээд хэсгийнхний дотроос шилдэг хөвгүүд залуучуудыг сонгон авч, тэдэнд тухайлсан боловсрол эзэмшүүлэх бодлогыг төрөөс явуулж байсанд оршино. Эл учрыг 1912 оны III сарын 30-ны өдрөөр өдөрлөсөн Ханд чин ванд Ж.Цэвээн абугайн бичиж өгсөн саналд “Гадаадын олон хүчирхэг улсын хамаг чадал ану гагцхүү элдэв ухааны эрдэм дор нэвтрэлцэн дээд, доорд, эр эм ялгад үгүй цөм бага наснаас эхлэн хирээр адаг, дунд их гурван зэргийн сургуулиаа явж, зүйл бүрийн ухааныг өөр өөрийн төрөлх хэл дээр судалснаар энэ мэт хүчирхэг болжээ. Бас манай монгол улс болбоос Чингис богдоос дараалан дээд үеийн өндөр хэдэн өвгөд эрдэмтдийг хэрэглэн чадсанаар алтан дэлхийг наран мандахаас наран шингэх хүртэл эзэлж, монголын хэцүү алдрыг ертөнцөд галав дүүртэл үлдээсэн билээ¹” хэмээн тайлбарласан аж.

Их эзэн богд Чингис хаан “...хүн хэдийбээр сэцэн төрөвч сургуулиас ангид мэргэн үл больюу, мэргэн сэцэн түшмэл улсын эрдэнэ²” хэмээсэн айлтгал нь Их Монгол улсын төрөөс боловсролын хэргийг нэн эрхэмд үзэж байсны илрэл болой. Энэ нь басхүү монголд элит боловсрол үүсч хөгжих аятай боломжийг бүрдүүлжээ.

Өгүүлэн буй үеийн элит боловсролын тогтолцоо нь тухайлсан сургууль, хишигтний доторх сургалт, ордны буюу гэрийн сургалт гэсэн 3 үндсэн хэлбэртэй байсан бололтой.

Тухайлсан сургуульд хамаарах нь Өгэдэй хааны үед 1233 онд Яньжин хотноо Их Монгол улсын хөвгүүдийн сургуулийг байгуулан анхны монгол 18 сурагчийг суралцуулж эхэлсэн явдал болой³. Эл сургуульд үндэслэн 1271 онд Монгол улсын хөвгүүдийн сургуулийг байгуулжээ: Тус сургууль монгол хэлээр сургалтаа явуулдаг, төрийн хэрэг, хэл бичгийн өндөр боловсролтой, монгол төрийн албан хаагчдыг бэлтгэдэг, монголын түүхэн дэх анхны дээд боловсролын байгууллага байсан төдийгүй дорно дахинд тухайн үедээ хамгийн том бөгөөд нэр нөлөө бүхий сургууль байсан аж. Энэ нь 1287 онд батлагдсан Юан улсын хөвгүүдийн сургуулийн дүрмэнд тодорхойлсон түүний зорилго, сургалтын агуулга, бүтэц, зохион байгуулалтаас тодорхой харагдаж байна⁴. Тэрчлэн XIII зуунд европ дахинаа “их сургуулийн

¹ Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй. УБ., 1964, 41 дэх талаас дам авлаа.

² Г.Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг, II дэвтэр, УБ., 1992. 32 дахь тал

³ Д.Наран. Монголын төр ёсны боловсролын түүх. УБ., 2001, 37 дахь тал

⁴ Мөн тэнд 87-94 дэх тал

хувьсгал” гэж түүхэнд нэрлэгдсэн үйл явц өрнөж, Англи Франц зэрэг улс оронд анхны их сургуулиуд байгуулагдаж байлаа. Тухайн үедээ хөгжлийн түвшингээр тэднээс дутаахгүй байсан Монгол гүрэн энэ үйл явцын гадна байсан гэхэд итгэхэд хэцүү. Гэвч монголын дээд боловсролын эл уламжлал тасарсан нэгэн гашуун үнэн боловсролын түүхэнд тохиосон бөлгөө.

Харин XX зууны эхэн үеэс тасарсныг залгах үйл соёлж эхэлжээ. XX зууны 10-аад оны үед бага, дунд зэргийн сургуулийн танхимын дүрэм хэмжээ гарч байсан байна. Дунд зэргийн сургуулийн танхимын дүрэм хэмжээний тав дугаар бөлөгийн 28 дугаар зүйлд “Дунд зэргийн сургуулийн танхимын сургуулийн хөвгүүдийг таван жилийн хугацаа дуусгасан удаа бүр ... нарийвчлан шалгаад, ... дээд зэргийн сургуулийн танхим дор оруулж, дээд зэргийн эрдэм чадал сурган боловсруулах буюу эсхүл зарим нэгэн онц сэргэлэнг ину гадаад улсдор илгээж, тусгай эрдэм чадал сургаж⁵...” гэж заасан нь улс оронд бага, дунд, дээд сургуулийг байгуулж, боловсролын нэгдсэн систем тогтоохыг санан сэдэж байсныг гэрчилнэ.

Тэрчлэн Зарлигаар тогтоосон “Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн долдугаар дэвтэр, Түшмэлийн засаг гэдэг зүйлд⁶ дээд сургуулийн тухай өгүүлсэн нь бий.

XX зууны монголын дээд боловсролын хөгжил өөрийн түүхнээ хэд хэдэн шатыг дамжсан байна. **Эхний шатыг 1910-аад оноос 1942 он хүртлэх хугацаанд хамруулан авч үзэж болно.** Эл шатанд улс орондоо орчин цагийн дээд сургууль байгуулах бэлтгэл ажлыг хангах, тасарсныг залгаж, эвдэрснийг эвлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа өрнөж байлаа. Энэхүү үйлийг дараах хэд хэдэн чиглэлээр авч үзэж болно.

1.Бүрэн дунд боловсролын сургуулийг байгуулан, суралцагчдад энэ шатны боловсрол эзэмшүүлэх ажлыг хийснээр дээд сургуульд элсэгчдийг бэлтгэх гол нөхцөл хэмээн үзэж байлаа. Олноо өргөгдсөн Монгол улсын үед бага болон дунд зэргийн сургуулийн танхимын дүрэм хэмжээг Гадаад хэргийн бүгд эрхлэн шийтгэх яамнаас⁷ хянан тогтоож гаргасан агаад сургуулиудыг байгуулж байлаа. 1911-1919 онд манай оронд хэдэн бага дунд сургууль байсан талаар судалгааны хүрээнд хэд хэдэн тоо байдаг.

1921 оны хувьсгалын дараагаар төрийн бага дунд сургуулиудыг шинээр байгуулж байлаа. 1940 гэхэд манай улсад ерөнхий боловсролын 331 сургуульд 24,3 мянган сурагч суралцаж байсан байна⁸.

2.Тусгай мэргэжлийн дунд сургуулиудыг байгуулж хичээллүүлж байсан нь мэргэжилтэн бэлтгэх дээд сургуулийг байгуулах бэлтгэл ажлын нэг болж байсан гэж хэлж болно.1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараагаар Оюутны сургууль, Багш нарыг бэлтгэх сургууль, Санхүүгийн болон худалдааны техникум зэрэг сургуулиуд байгуулагдан 1940 гэхэд 1,3 мянган суралцагч бүхий 7 тусгай мэргэжлийн дунд сургууль хичээллэж байлаа⁹.

3.Гадаадын ялангуяа ЗХУ-ын дээд сургуулиудад суралцагчдын тоо нэмэгдэн улс орондоо дээд боловсролтой мэргэжилтэн нарыг бэлтгэж эхэлсэн байна. ЗХУ-ын их дээд сургуулиудад суралцагчдыг бэлтгэхэд Улаан-Үд хот дахь Монгол рабфак чухал үүрэг гүйцэтгэж байлаа.

4.Судалгаа шинжилгээний байгууллагын эх үүсвэрийг тавьж, эрдэм судлалын ажлыг эрхлэх Судар бичгийн хүрээлэнг 1921 онд байгуулсан аж.

Ийнхүү дээд сургуулийг байгуулах боломж бүрдсэний сацуу нийгмийн хэрэгцээ шаардлага ч байлаа. Эл асуудлыг тухайн үед “Манай улс... ардын аж ахуй, соёл боловсролыг

⁵ Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй. УБ., 1964, 53 дэх талаас дам авлаа.

⁶ Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг

⁷ Энэ үед сургуулийн хэргийг Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэх яам эрхэлж байлаа.

⁸ БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд. /1921-1991/ УБ., 1991, 106 дахь тал

⁹ Мөн тэнд

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

онц дэлгэрүүлж байгаа явдал багш, эмч, зоотехникч, инженер зэргийн дээд мэргэжилтэй өөрийн үндэсний боловсон хүчнүүдийг бэлтгэн төрүүлэх тухай шаардмой” гэж үзэж байлаа.

Эл үзэл санаа цаашид өргөжин тэлсээр 1940-өөд онтой золгосон байна. 1942 онд манай улсад орчин цагийн дээд сургууль-МУИС байгуулагдсан нь гэгээрэл боловсролын түүхнээ онцгой ач холбогдолтой ариун гэгээн үйлс болсон билээ. Ингэснээр манай дээд боловсролын хөгжлийн 2 дахь шат эхэлж 1980-аад оны эцэс хүртэл үргэлжилсэн байна. Энэ шатны гол үр дүн гэвэл:

- Орчин цагийн монголын дээд боловсролын загалмайлсан эцэг-МУИС одоогийн Шинжлэх ухаан технологийн их сургууль (ШУТИС), Монгол улсын боловсролын их сургууль (МУБИС), Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль (ЭМШУИС), Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС), Хүмүүнлэгийн ухааны их сургууль (ХУИС) зэрэг төрийн өмчийн олон сургуулиудыг төрүүлэн гаргасан нь одоо нэгэнтээ гар нь ганзганд, хөл нь дөрөөнд хүрчээ. Ийнхүү монголын дээд боловсролын систем бүрэлдэн тогтсон аж. 1990 оны байдлаар манай оронд их дээд сургууль 9 ажиллаж байсны нэг нь л их сургуулийн статустай байлаа.
- Улс орондоо дээд боловсролтой олон арван мянган мэргэжилтэнг бэлтгэсэн байна. Үүнийг статистикийн баримтаар дор харуулав.

Дээд сургууль төгсөгчдийн тоо /мянган хүнээр/¹⁰

№	Салбар / он	1960	1970	1975	1980	1985	1990
1	Нийт төгсөгчид	1,1	1,8	1,7	3,0	5,0	2,8
2	Үүнээс Үйлдвэр, дэд бүтцийн	0,2	0,4	0,5	1,0	1,5	0,8
3	Хөдөө аж ахуйн	0,13	0,2	0,3	0,3	0,5	0,3
4	Эдийн засаг хууль	0,31	0,3	0,2	0,7	1,0	0,6
5	Эрүүлийг хамгаалах, биеийн тамирын	0,13	0,2	0,2	0,3	0,4	0,4
6	Соёл боловсрол, урлаг	0,37	0,7	0,5	0,7	1,6	0,7
7	Гадаадын дээд сургууль төгсөгчид	0,1	0,3	0,2	0,5	1,1	0,7

Дээр өгүүлсэн баримтаас үзэхэд дээд сургуулийг төгсөгчид 1990 оныг эс тооцвол жил бүр нэмэгдэж ирсэн байна. Аж үйлдвэр, дэд бүтэц, эдийн засаг, хууль, соёл боловсрол, урлагийн салбарт дээд боловсролтой мэргэжилтэнг илүү түлхүү бэлдэж байлаа. Өгүүлэн буй үед дээд сургуульд элсэгчид, дээд боловсрол эзэмшигчдийн тоог улсаас тухайлан тогтоож төлөвлөгөө, бодлогоор төрөөс зохицуулдаг механизм үйлчилж байлаа. Дээд сургууль төгсөгчид нь эх орныхоо бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулж байлаа.

- Их дээд сургуулиуд улс орныхоо эрдэм шинжилгээний ажлын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулдаг болж, судалгаа шинжилгээний ажлын нэгэн гол төвүүд болж байлаа.
- Их дээд сургуулийн оюутнууд суралцахын сацуу улс орныхоо хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрээ оруулах хөдөлгөөн нийтийн хүртээл болон өрнөж, хөдөө орон нутагт

¹⁰ БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд, УБ., 1991, 112-113 дахь тал

хашаажуулах, усжуулах зэрэг ажилд амралтын үеэр ажилладаг, барилга байгууламжинд ажиллах оюутны отрядыг зохион байгуулах, намрын ургац хураалтын үеийн гол ажлыг нугаладаг уламжлал тогтсон байлаа.

Өнгөрсөн тогтоцооны үед манай дээд боловсролын системийн хөгжил алдаа, онооны аль алинийг нь агуулсаар ирсэн байна. Энэ үеийн монголын дээд боловсролын систем нь ЗХУ-ын дээд боловсролын системийг хуулбарласан шинжтэй, дан ганц төрийн өмч ноёрхсон, их дээд сургуулийн элсэлт, төгсөлт, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг эрх баригч нам, засгаас зохицуулдаг, нийгмийн хэрэгцээ шаардлагыг туйлшруулан үнэлж, хувь хүний хэрэгцээ шаардлагыг төдийлэн анхаардаггүй байсан, сургалтын агуулга академик шинж голлосон, ялангуяа нийгмийн ухааны сургалтын агуулга үзэл сурталжсан, улс төржсөн, төвлөрөл хүчтэй, өрсөлдөөн үгүй байсан зэрэг шинжүүд зонхилж байлаа.

Монголын дээд боловсролын ХХ зууны хөгжил 1990-ээд оноос шинэ шатанд шилжсэн байна. Монголын нийгмийг хамарсан өөрчлөлт, шинэчлэлийн гадна дээд боловсролын салбар үлдсэнгүй. **1990-ээд оны эхэн үеэс эхэлж буй ХХ зууны монголын дээд боловсролын хөгжлийн 3 дахь шатанд** энэ салбарт ихээхэн өөрчлөлт хийгдлээ. Энэ үед манай орны дээд боловсролын шинэчлэлийн үйл явцыг дараах хэсгүүдэд бүлэглэн хувааж, авч үзэж болох юм. Үүнд:

1. Дээд боловсролын салбарын эрх зүйн шинэ орчин бүрэлдэн бий боллоо. Монгол улсын УИХ 1995 онд Монгол улсын Боловсролын багц хууль¹¹, Боловсролын салбарт төрөөс баримтлах бодлогыг батлан гаргасан байна. Үүнээс өмнө дээд боловсролын харилцааг эрх баригч намын тогтоол шийдвэр, төр засгаас гаргасан дүрэм, журмаар голлон зохицуулж ирсэн байдаг. Уг багц хуулинд 1998 онд нэмэлт өөрчлөлт оруулсан агаад 2002 онд шинэчлэн баталсан байна. “Дээд боловсролын тухай” Монгол улсын хуулиар энэ шатны боловсролын зорилго, агуулга, сургалтын байгууллага, сургалтын зохион байгуулалт, удирдлага, сургалтын байгууллагын бүрэн эрх, багш, суралцагчийн эрх, үүрэг, дээд боловсролын эдийн засаг, нийгмийн баталгаа зэрэг асуудлыг хуульчлан зааж өгсөн байна¹².

2. Дээд боловсролын салбарт бүтцийн өөрчлөлт хийгдэж, төрийн монополь задарлаа. 1990 оноос манай оронд хувийн өмчийн дээд сургууль, коллеж байгуулагдаж эхлэв. 2004 оны байдлаар 174 их дээд сургууль, коллеж сургалт, эрдэм шинжилгээний ажил эрхэлж байгаагийн дотор дийлэнх олонх нь (ялангуяа хувийн өмчийн сургуулиудын) нийгэм хүмүүнлэгийн ухааны салбарын сургуулиуд байна¹³. Сүүлийн жилүүдэд энэ шатны сургуулиуд олноор байгуулагдаж байгаа нь тухайн салбарт өрсөлдөөнийг бий болгож, боловсролын чанарыг дээшлүүлэх нэгэн хөшүүрэг болж байна. Гэвч эл үйл явцыг монголын нийгмийн сэтгэл зүй наад зах нь 2 байдлаар хүлээн авч үнэлж байна. Нэг хэсэг нь олон сургуулиуд байгуулагдаж байгаа нь хир хэмжээнээс хэтэрсэн зохисгүй үйл явц гэж сөргөөр хандаж байхад нөгөө хэсэг нь дэлхий дахинд бүх нийтийн дээд боловсрол олгох чиг хандлага гарч байна гэж үзэж түүнтэй уялдуулан эерэг талаас үнэлж байна. Хэдийбээр улсын нийт хүн амын тоонд харьцуулан үзвэл хэт олон дээд сургууль байгаа мэт боловч энэ салбарын чөлөөт өрсөлдөөний явцад шалгарал явагдаж, амьдрах чадвартай сургууль нь оршин тогтнох хандлага ажиглагдаж эхэллээ. Үүнийг зөвхөн 2004 онд 10 гаруй дээд сургууль коллеж үүдээ хаасан ба сүүлийн 3 жилд дээд сургууль, коллеж шинээр байгуулагдах үйл явц эрс цөөрсөн зэрэг баримт харуулж байна.

¹¹ “Боловсролын багц хууль”-д “Монгол улсын боловсролын хууль”, “Монгол улсын бага дунд боловсролын хууль”, “Монгол улсын дээд боловсролын хууль” зэргийг багтаан хэлж байна

¹² “Дээд боловсролын тухай” Монгол улсын хууль. Төрийн мэдээлэл, УБ., 2002, №19, 669-674 дэх тал

¹³ Монгол улсын үндэсний статистикийн газрын тоон мэдээг ашиглав.

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Дээд боловсролын бүтцэд гарсан нэгэн өөрчлөлт бол шаталсан сургалтанд шилжсэн явдал билээ. 1990-ээд оноос коллеж бакалаврын, дээд сургууль бакалавр, магистрын, их сургууль бакалавр, магистр, докторын сургалтыг эрхлэх болсон байна¹⁴. Ийнхүү өнгөрсөн тогтолцооны үед мэргэжлийн тусгай дунд боловсрол олгож байсан техникумууд ихэнхдээ коллеж болж өөрчлөгдөн, дээд сургуулиар магистрын зэргийн сургалтыг шинээр явуулах болсон байна. Жишээлбэл МУИС анх 1992 онд магистрын зэргийн сургалтыг нээн хичээллүүлж, 1993 онд анхны 13 хүнийг төгсгөсөн байна. Магистр, докторын зэргийн сургалт нь гол төлөв сургалтын хэлбэртэй байгаа боловч судалгаанд суурилсан сургалт басхүү хэрэгжиж байна.

3. Дээд боловсролын агуулгад үндсэн өөрчлөлт гарлаа. “Дээд боловсролын тухай” Монгол улсын хуулинд “Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчдад шинжлэх ухаан технологи, нийгэм хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгээ нээж хөгжүүлэх, мэдлэг, чадвар дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ¹⁵” гэж тодорхойлсон байна. Манай орны дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэжих гэсэн 3 хэсгээс бүрддэг.

Дээд боловсролын салбарт дэлхийн олонх орнуудын мэргэжлийн боловсролын агуулгыг хэмждэг нийтлэг нэгж болох кредит цагийг 1990-ээд оноос хэрэглэх боллоо. 1994 онд ШУБЯ, Боловсролын хүрээлэнгээс кредитийн систем нэвтрүүлэх журам¹⁶ аргачлалыг гаргаж хэрэгжүүлсэн байна. 1995 онд батлагдсан “Дээд боловсролын тухай” хуулиар дээд боловсролын зэргийг кредит цагаар хэмжих заалтыг оруулснаар түүний эрх зүйн үндэс бүрэлдсэн байна.

Агуулгын өөрчлөлтэй уялдан сургалтын технологи, арга зүйн шинэчлэл хийгдэж байна. Сургалтын агуулгын шинэчлэлд сургалт, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нэгдлийг бүрэн хангах онолын болон практик мэдлэгийн харьцааг оновчтой тогтоох асуудал манай их дээд сургуулиудын анхарлын төвд байгаа бол технологийн шинэчлэлийн гол асуудал нь шинжлэх ухааны болон сургалтын танин мэдэхүйн холбоог ойртуулах, ялгааг нь арилгахад чиглэгдэж байна.

4. Дээд боловсрол эзэмшигчдийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлж, дүгнэх дүн, шалгуур зэрэгт өөрчлөлт орсон юм. Суралцагчийн мэдлэг чадварыг үнэлж байсан онц, сайн, дунд, муу, онцмуу гэсэн 5 баллын үнэлгээг 1994 оноос өөрчлөн үсгэн (A,B,C,D,F), тоон (4,3,2,1,0) болон процентон (1-100 хүртэл) дүнг хэрэглэх болсон байна. Тэрчлэн суралцагчийн улирлын болон суралцсан хугацааны агуулга эзэмшилтийн чанарын түвшинг тогтооход голч дүн гэсэн нэгжийг хэрэглэдэг болсон агаад түүнийг улирлын голч дүн, хуримтлуулсан голч дүн гэж 2 ангилдаг журам үйлчилж байна.

Дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааны төвшин, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргах зорилго бүхий боловсролын магадлан итгэмжлэлийг 1995 онд анх бий болгох эрх зүйн үндэс тавигдсан нь

¹⁴ 1995 онд гарсан “Монгол улсын дээд боловсролын хууль”-иар дээд боловсролын сургалтын байгууллагыг коллеж, дээд сургууль, их сургууль гэсэн ангилалтай байхаар заасан боловч 1998 онд уг хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр коллеж, их сургууль байхаар хуульчилжээ. Харин 2002 оны хуулиар дээрх 3 шатны байгууллага байхаар заасан байна.

¹⁵ “Дээд боловсролын тухай” Монгол улсын хууль. Төрийн мэдээлэл, УБ., 2002, №19, 669 дэх тал

¹⁶ Энэ журмыг 2003 онд өөрчлөн шинэчилсэн байна.

манай боловсролын салбарт гарсан цоо шинэ өөрчлөлт байлаа. Энэ хуулийн үндсэн дээр 1997 оны 12 дугаар сард Засгийн газар тогтоол гаргаж Дээд боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг (ДБМИҮЗ) байгуулахыг Гэгээрлийн яаманд даалгасан байна. Энэ үндсэн дээр 1998 онд ДБМИҮЗ-ийг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Уг зөвлөл 1999 оны 4 дүгээр сард Техникийн их сургууль, Анагаах ухааны их сургууль, “Монголбизнес” “Отгонтэнгэр” зэрэг 4 сургуульд 5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэл олгосон нь анхных байлаа.

2003 оноос сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эхэлж, 2004 онд ХААИС-ийн Мал эмнэлэг, биотехнологийн сургуулийн “Мал эмнэл зүй” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй малын их эмч бэлтгэх, ШУТИС-ийн Холбоо мэдээллийн сургуулийн “Цахилгаан холбоо мэргэжлээр бакалаврын болон магистрын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрүүдийг тус бүр 5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжилсэн нь энэ чиглэлээр ууган нь болсон байна.

Магадлан итгэмжлэх байгууллагын үүрэг зорилт өргөжсөн, шинээр мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны түвшин, сургалтын хөтөлбөрийн чанарт хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ хийх болсонтой холбогдон ДБМИҮЗ-ийг 2004 оны 3 дугаар сард Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл болгон өөрлөн байгуулсан байна.

5. Дээд боловсролын удирдлага, санхүүжүүлэлтэнд томоохон өөрчлөлт гарлаа. Манай улсад дээд боловсролын удирдлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлдэг агаад дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааг төрийн бодлогын хүрээнд уялдуулан зохицуулж, дэмжих, тэднийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах, төрийн захиргааны бусад төв байгууллагатай тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлаар хамтран ажиллах зэрэг эрхийг хэрэгжүүлдэг.

Дээд боловсролын сургалтын байгууллага нь өөрийн удирдлагын зарчмыг баримтлах ба түүнийг сургуулийн удирдах зөвлөл хэрэгжүүлдэг. Анх 1995 онд гарсан “Боловсролын тухай” Монгол улсын хуулинд Удирдах зөвлөлийн байгуулагдах эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн билээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагч, багш, суралцагч, төгсөгчийн төлөөлөлтэй байх бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу сургуулийг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр дүрмийг батлах, өөрчлөх, сургуулийн бүтэц зохион байгуулалт орон тоо, цалингийн нийт хэмжээг тогтоох, хөрөнгө оруулалт жилийн төсвийн хуваарилалтыг баталж, зарцуулалтанд нь хяналт тавих, сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох, сургуулийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Дээд боловсролын байгууллагыг дан ганц төсвөөс санхүүжүүлдэг өнгөрсөн тогтолцооны үеийн журмыг 1990-ээд оны эхээр халсан юм. Одоо төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгө, эрдэм шинжилгээ судалгааны ажлын төслийн санхүүжилт, сургалтын төлбөр, аж ахуйн үйл ажиллагааны орлого, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, зээл, тусламж, бусад эх үүсвэрээс бүрдэж байна. Дээд боловсролыг хувь хүний хувьд үнэ төлбөргүй төдийгүй суралцагчдад стипенди олгох замаар олгодог байсан тогтолцоог халж, сургалтыг төлбөртэй болгосон юм. Одоо дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрөө хувиараа, төрийн хөнгөлөлттэй зээлээр төлөхийн зэрэгцээ төрийн албан хаагчдын 1 хүүхдийн сургалтын төлбөр, нэн ядуу болон малчин өрхийн хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцаж байна. Тэрчлэн амжилттай сайн суралцсан суралцагчийн сургалтын төлбөрийг хөнгөлдөг журам үйлчилж байна.

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Дээр өгүүлснийг товчоолон үзвээс XX зууны монголын дээд боловсролын хөгжлийн түүхийг үндсэнд нь 3 шатанд хуваан үзэж болох байна Үүнд:

Нэгдүгээр шат. Монголд орчин цагийн дээд боловсролын системийг бий болгох бэтгэл үе агаад энэ нь 1910-аад оноос 1942 оныг хүртэл үргэлжиж байна. Өгүүлэн буй шатанд ерөнхий боловсролын дунд сургуулийг байгуулан бэхжүүлж дээд сургуульд элсэгчдийн нөөцийг бий болгох, дээд сургууль байгуулахад чиглэсэн эдийн засаг нийгмийн шинжтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үйл явц зонхилж байлаа.

Хоёрдугаар шат. Орчин цагийн дээд боловсролын систем үүсч хөгжсөн үе агаад 1942-1980-аад оны эцэс хүртэлх хугацааг хамаарч байна. Эл шатны үндсэн агуулга нь төрийн өмчийн их дээд сургуулиуд байгуулагдан, улс орондоо дээд боловсролтой олон арван мянган мэргэжилтэнг бэлтгэн өгч эх орны шинжлэх ухааныг хөгжүүлэх өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж ирсэн явдал болой. Гэхдээ энэ шатанд монголын дээд боловсрол шулуун дардан замаар явсангүй. Монголд орчин цагийн дээд боловсролын систем үүсэн хөгжихөд ЗХУ-ын /хуучин нэрээр/ тусламж, дэмжлэг ихээхэн ач холбогдолтой байсныг тэмдэглэвэл зохилтой.

Гуравдугаар шат. Монголын дээд боловсролын шинэчлэл, өөрчлөлтийн шат. Энэ нь 1990-ээд оноос эхэлж байгаа ба дээд боловсролын эрх зүйн шинэ орчин бүрэлдэн бий болж, дэлхийн дээд боловсролын жишигт монголын сургуулиудыг хүргэх чиг хандлага барьсан өөрчлөлт, шинэчлэл хийгдэж байна.

SUMMARY

Mongolian higher education system has its root in the thirteenth century. Yet, the twentieth century's Mongolian educational system's history can be divided roughly into three periods. The periods are as follow:

The first is the preparatory period for the establishing of modern educational system in Mongolia and it covers the period of 1921 to 1942. In this period, economic and social measures that aimed to establish and strengthen the secondary schools and train students which would be enrolled later on into higher educational institutes were dominated. As well as, preparatory measures were taken to establish higher educational institutions.

The second period is the period when the modern higher educational system was established in Mongolia and it lasted until the end of 1980s. The period were characterized by the establishment of state owned universities and institutes that contributed to the development of country's science and technology by training tens of thousands of specialists. However, the establishment and development of higher education system in Mongolia was not that smooth. It should be acknowledged that former USSR's assistance and support were very important for the development of higher educational system in Mongolia.

Third period is the period of restructuring of Mongolia's higher educational system. The period starts from the 1990s and changes and innovations that aimed to create a new legal environment for higher education have been taken. Improving of Mongolia's higher education to the world standard has been the main aim of the higher educational restructuring.

Ашиласан материал, ном, бүтээл

1. БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд /1921-1991/, УБ., 1999.
2. "Дээд боловсролын тухай" Монгол улсын хууль, "Төрийн мэдээлэл", УБ., 2002, №19
3. Монголын дээд боловсрол: XXI зууны үзэл баримтлал, УБ., 1999.
4. Д.Наран. Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001.
5. Б.Ринчин. Монгол бичгийн хэлний зүй. УБ., 1964.